

ХҮНИЙ ҮҮСЛИЙН ТУХАЙ АСУУДАЛД

Б.Палгаа

Монгол Улсын Их сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Хүн төрөлхтөний соёл иргэншлийн түүхийн зангилаа асуудлын нэг орчин үеийн хүн, хүн дүрст мичнээс ямар ямар үе шатыг дамжин хэдий үед бий болсон, хүний биеийн ямар эрхтнүүд нөлөөлсөн, хөдөлмөр түүний үйл ажиллагааны үр дүнд орчин үеийн хүн бий болоход шийдвэрлэх алхам болсныг, Монгол орон, хүн үүссэн өлгий уугуул нутгийн нэг болохыг түүхэн сурвалж, эл өглөгийн зүйлс, холбогдох судалгааны бүтээлийг ашиглан гаргасан юм.

Түлхүүр үг: Парапитек, проплиопитек, дриопитек, рамапитек, Австралопитек, гейдельбург, зинжантроп, презинжантроп, питекантроп, синантроп, неандерталь, кро-маньон. Төв Ази, Монголын их говь. Аляск, Алеут.

Хүй нэгдлийн нийгмийн хөгжлийн зүй тогтлын тухай ойлголт нь анх бий болсон цагаасаа эхлэн тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байсан хүний өөрийн нь бие бялдарын тасралтгүй өөрчлөлттэй нягт холбоотой юм. Тиймээс эрт дээр үеийн хүний хөдөлмөрийн үйл ажиллагааны үе шат болсон нийгмийн байгууллын үүслийг **“Хүний өөрийнх нь биологийн түүхээс салган үзэж болохгүй юм”**¹ гэж Английн зоологич Томас Гексли хэлсэн билээ.

Хүн анх хүн дүрст мичнээс үүссэн тухай XVIII зууны дунд үеэс эхлэн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тавигджээ. 1871 онд Ч.Дарвин “Эртний хүн дүрст дриопитекийн олдвор олдсоноор хүн дүрст мичнээс хүн үүссэн”² гэсэн онолыг дэвшүүлснээр энэхүү асуудал хөдөлшгүй үнэн болох нь шинжлэх ухаанд батлагджээ. Ийнхүү XIX-XX зууны үед явуулсан олон арван судалгааны үр дүнд хүн адгуусан төрлийн мичнээс хүн үүссэн тухай таамаглал үнэн зөв болох нь нэгэнт шийдвэрлэгдсэн юм. Харин хүн, нэн эртний мичнээс үүссэн нь нэгэнт тодорхой боловч чухам ямар төрлийн мичнээс үүссэн болох нь маргаантай байсан боловч сүүлийн үеийн судалгаагаар сөнөж үгүй болсон “Хомо” төрлийн мичнээс үүссэн болох нь судалгаагаар нэгэнт батлагдаж байгаа юм.

Хүн дүрст мичнээс хүн орчин үеийн хүн үүсэхэд, чухам хүү хүний биеийн ямар эрхтэн нь чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг судлаачид янз бүрээр тайлбарлаж ирсэн билээ. Тухайлбал зарим судлаачид **“Хойт хоёр хөл дээрээ явж чаддаг болсон нь мичнээс хүн болоход чухал үүрэг гүйцэтгэсэн”** гэж үзэж байхад, нөгөө хэсэг судлаачид нь **“гарын нөлөө чухал үүрэг гүйцэтгэсэн”** гэсэн бол нилээд хэсэг нь **“Уураг тархины нөлөө томоохон үүрэгтэй байсан”** гэх мэтээр янз бүрийн таамаглал дэвшүүлж байсан юм. Тэгвэл Ф.Энгельс хэлэхдээ: **“Гар, үгүүлэх эрхтэн, уураг тархины хамтын ажиллагааны үрээр хүмүүс тус бүрээр зогсохгүй, мөн нийт нийгэмдээ улам бүр нарийн ажиллагаа хийх, улам бүр их зүйлийг зорих, түүндээ хүрэх чадварыг олж, үүгээр мич хүн болоход шилжилтийн шийдвэрлэгч алхам”**³ болжээ.

Түүнчлэн олны анхаарлыг татсан таамаглалын нэг нь Ч.Дарвиных бөгөөд тэрээр **“Хүний үүсэл ба бэлэгийн шалгарал” зохиолдоо морфологийн онцлог бүхий мичин хүн нь бэлэгийн шалгаралаар түргэн үржиж, үүгээрээ хүний**

¹ К.И.Козлова. История первобытного общества и основы этнографии. М.1984. с.19

² К.М.Неструх. Происхождение человека. М.1970. с.19

³ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III боть.УБ., 1971. тал 81

төрөл тодорхой чиглэлээр хөгжих явцад шийдвэрлэх алхам үзүүлсэн" гэх мэтээр тайлбарлажээ⁴.

Гэвч эдгээр дэвшүүлсэн таамаглал нь орчин үеийн хүн бий болоход чухал нөлөө үзүүлсэн боловч хүн үүсэн хөгжих жинхэнэ бодит байдлыг бүрэн дүүрэн гаргаж чадаагүй гэж үздэг. Хүн үүсэх явцад үзүүлсэн нийгмийн хүчин зүйл нь Ф.Энгельсийн тодорхойлсноор **"ганцхан хөдөлмөр хүнийг өөрийг нь бий болгосон"**⁵ гэсэн сонгодог дүгнэлтийг хийсэн бөгөөд юуны өмнө өөрсдийгөө хооллох, зэрлэг ан амьтнаас биеэ хамгаалах зэрэг өөрсдийнхөө хэрэгцээг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, хөдөлмөрийн үйл ажиллагаа нь дөрөвдөх галавын (кайнозой) туршид хүний тархины үйл ажиллагааг өөрчлөн эцсийн үр дүнд орчин үеийн хүн, хүний нийгмийн бий болгосон хүчин зүйл болжээ.

Гуравдагч галавын эцэст амьдарч байсан хүний өвөг болох хүн дүрст мич нь одоогийн ихэнх мичний нэгэн адил нийгмийн байсан нь хоол хүнсээ хамтарч олох, хамт олноороо бие биеэ хамгаалах зэрэг үйл ажиллагаагаар илэрч байсан билээ. Анх байгалийн бэлэн чулуу, мод шийдэмийг дээрхи зорилгодоо ашиглан дараа нь өөрсдөө болхи бүдүүлэг хөдөлмөрийн багаж зэвсэг хийх болсон нь тэднээс байгалийн төрөл бүрийн бүтээгдэхүүнийг урьд урьдынхаас илүү их хэмжээгээр ашиглах боломжийг бий болгожээ.

Эртний хүмүүс хамтын хүч хөдөлмөрөөр хоол хүнсээ олох, хөдөлмөрийн багаж зэвсгээ хийх зэрэг хамтын хөдөлмөрийн үрээр хүй нэгдлийн анхны хамтлаг-Хүн сүрэг бий болжээ. Ийнхүү үйлдвэрлэлийн процессын явцад тэдгээр хүмүүсийн хооронд ямар нэг хэмжээгээр хэлхээ холбоо тогтжээ. Үүний дараа нийгмийн амьдрал, үйлдвэрлэлийн үйл явц хөгжин нарийсах тутам үйлдвэрлэлийн туршлага дадлаа харилцан солилцох буюу үр удамдаа өвлөн шилжүүлэх шаардлага урган гарсан нь бие биетэйгээ хэл яриагаа харилцахад аажимдаа хүргэсэн байна. Тиймээс ч Ф.Энгельс **"Хөдөлмөрийн үйл ажиллагаа нь нийгмийн гишүүдийг улам их нягтруулахад зайлшгүй тус дөхөм"**, болоод **зогсоогүй "Хөдөлмөрийн процессоос, хөдөлмөртэй хамт хэл үүссэн"**⁶ гэж тодорхойлсон байдаг.

Гуравдагч галавын эцсийн үед амьдарч байсан хүн дүрст мичний үлдэц Африк, баруун Ази, Европ зэрэг нилээд газраас арвин ихээр олдсон юм. Эдгээр хүн дүрст мичний дотроос орчин үеийн хүнтэй нилээд төсөөтэй нь Дриопитек (модны мич) төрлийн мич билээ.

Дриопитек нь орчин үеийн павиан, шимпанзтай хэмжээний хувьд ойролцоо боловч бусад мичнүүдэй харьцуулахад шүдний зохион байгуулалт ялангуяа үүдэн шүд, соёоны хоорондох зай болон соёо нь багавтар байгаа нь орчин үеийн хүнийхтэй нилээд төсөөтэй байгаа юм⁷. Тэрчлэн 1920-иод оны үеэс одоо хүртэл олдож байгаа мичин хүний олдворыг судлаачид Австралопитек, Парантроп, Плезионтроп гэж гурван хэсэгт хувааж үздэг бөгөөд тэдний тархины багтаамж нь дунджаар 550-600см³ хойт хоёр хөл дээрээ явж чаддаг байв⁸. Ялангуяа австралопитекийн аарцагны дунд чөмөгний яс нь хүнийхтэй нилээд ойролцоо, тэр нь зөвхөн байгалийн бэлэн мод, чулуу ашиглахын зэрэгцээ түүнийгээ аажмаар засаж янзлан болхи хөдөлмөрийн багаж зэвсгийг хийх болсноор хүний нийгмийн түүхэнд томоохон дэвшил гаргасан гэж олон судлаачид дүгнэсэн байдаг. Нөгөө талаар австралопитекуудтай хамт олдсон төрөл бүрийн амьтдын яснуудыг шинжлэн үзэхэд тэдгээр нь жижиг амьтдыг хоол хүнсэндээ хэрэглэж байсан бөгөөд

⁴ Ч.Дарвин. Происхождение человек и половой отбор. М.1963г.с.198

⁵ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III боть.УБ., 1971. тал 74

⁶ К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III боть. УБ., 1971. тал 77

⁷ М.Ф.Неструх, Происхождение человека, М.1970

⁸ В.П.Алексеев. А.И.Першиц. История первобытного общества. М.1999, с.90

ийнхүү "... **махыг идшэнд хэрэглэх болсон нь хүн болж хувирахад нэг шинэ чухал алхам болжээ**"⁹ гэсэн Ф.Энгельсийн үзэл санааг батлаж байгаа юм. Дээр дурьдсан хүний эртний өвгөөс гадна 1959 онд дорнод Африкийн Олдовай уулын дөрөвдэх давхаргаас 1,5 сая жилийн өмнө амьдарч байсан **"Зинжантроп"** гэж нэрлэсэн хүн дүрст мичний бараг бүтэн гавалын яс олдсон юм. Тэр нь хойт хоёр хөл дээр явдаг, шүдний зохион байгуулалт нь хүнийхтэй нилээд төсөөтэй байсан юм¹⁰.

1960 онд дээрх Олдовай уулын хавцлаас Английн палеонтологич Л.Лики, чадварлаг хүн гэж нэршсэн хүний үлдэц, болхи зэвсгийн хамт олдсон нь зинжантропоос өмнөх үед (1.750.000 жил) холбогдох тул презинжантроп буюу чадварлаг хүн гэж нэрлэж иржээ. Тархины багтаамж нь 670-680 см³ ¹¹. Тэрчлэн түүнээс өмнөх үеийн мичин хүний үлдэцийг 1967 оны үеэс эхлэн Этиопын Омо голын Хадар орчмоос олсон нь австралопитекийн төрөлд хамаарагдах төдийгүй 4-2 сая жилийн өмнө амьдарч байсан болохыг калий-аргоны аргаар судлан шинжлэн тодорхойлжээ¹². Ийнхүү гуравдагч галавын эцэс, дөрөвдөгч галавын эхэн үеийн хүн дүрст мичний үлдэц бараг тив бүхнээс олдсон бөгөөд тэдгээрийн хооронд ижилдүү байснаас үзэхэд манай гарагийн чухам аль хэсэгт хүн дүрст мичнээс орчин хүн бий болох процесс явагдсаныг нарийн тодорхойлон шийдвэрлэхэд бэрхшээлтэй боловч, геологий, эртний ургамал, цаг агаар судлах шинжлэх ухааны судалгааг үндэслэн ихэнх судлаачид төв болон Өмнөд Африк, Төв Азийн нутгийг хүн үүсэн бий болоход хамгийн тохиромжтой нутаг гэж үздэг юм.

Хүн дүрст мичнээс хүнд шилжих шилжилтийн үеийн хүний үлдэцийг 1890-1891 онд Ява арлын Соло голын эрэг дэх Трипил орчмоос Голландын эмч Э.Дюбу, түрүү плейстоцены давхаргаас олж шинжлэх ухааны судалгаанд оруулсан юм¹³. Эндээс олдсон хүний хөл, гавлын ясны үлдэцийг судлахад **тархины багтаамж нь 800-950 см³, хойт хоёр хөлөн дээрээ босоо явж чаддаг дух нь ар тийшээ налуу, хөмсөгний яс нь урагшаа товойн гарсан нь мичтэй төсөөтэй байсныг тогтоож, питекантроп буюу мичин хүн** гэж нэрлэжээ. Түүнчлэн питекантропын хамт болхи бүдүүлэгдүү боловч зориуд засаж янзалсан чулуун зэвсэг олдсон нь эртний хүмүүс хамгийн анх өөрсдөө үйлдэж хийсэн хөдөлмөрийн багаж зэвсэг байсан учраас энэ үеэс хүний түүх эхэлсэн гэж ихэнх судлаачид үздэг¹⁴.

Питекантропын дараагийн үед холбогдох хүний үлдэгдэл 1920, 1930-аад оны үеэс эхлэн олдсон бөгөөд анх 1927 онд Бээжин хотын ойролцоох Чжоу-коудян агуйгаас олджээ. Тэнд эрэгтэй, эмэгтэй хүний болон хүүхдийн 40-өөд хүний төрөл бүрийн ясны үлдэгдэл байсан нь питекантропыг бодвол орчин үеийн хүнийхтэй улам ойр төрх шинжтэй байжээ. Тэдгээрийн тархины багтаамж нь дунджаар 900-1200 см³ бөгөөд дундат плейстоцены үед холбогдох энэхүү хүнийг **"Синантроп"** ¹⁵ гэж нэрлэжээ. (Бээжин хүн)

Тус агуйнуудад хийсэн малталтаас үзэхэд Синантроп нь нилээд олон хэлбэрийн чулуун зэвсгүүдийг хийж, буга, зэрлэг адуу зэрэг томоохон амьтдыг агнаж байсан төдийгүй, элсэрхэг өөхөн чулуу, цахиур зэргийг хагалан голын хайрганд ирлэн заазуур, хутга зэрэг хөдөлмөрийн багаж зэвсэг хийж байсан нь харагдаж байгаа юм. Мөн агуйгаас бараг 7 м шахам зузаан үнс олдсон нь гал

⁹ К.Марк, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III боть. УБ., 1971, тал 80

¹⁰ Всемирная история. Каменный век. В.24 томах. том I. М.1996. стр 30

¹¹ История древнего мира. М.1979 г. с.28

¹² А.И.Перциц, А.Л.Монгайт. В.И.Алексеев. История первобытного общества. М.1974г. с42

¹³ Всемирная история (каменный век) В 24 томах, том 1. М.1996. тал 34

¹⁴ К.И.Козлова. История первобытного общества и основы этнографии. М.1974; тал 26

¹⁵ М.Ф.Неструх. Происхождение человека. М.1970г. с.297

гарган ашиглаж байсны тодорхой гэрч юм. Тэрчлэн гавалын ясанд хийсэн шинжилгээнээс үзэхэд синантроп нь үг ярианы тусламжтайгаар хоорондоо ямар нэг хэмжээгээр ярилцаж байсан нь харагдаж байгаа юм. Гэвч Синантроп нь хэдийгээр хүний шинж төрхтэй нилээд ойртсон боловч хүн дүрст мичний морфологийн үлдэц болох гавалын яс нь хавтгайдуу, хөмсгөн яс нь шовгор, эрүүний яс нь хөгжөөгүй зэргээс үзэхэд мичний зарим шинжээс бүрэн ангирч чадаагүй байгааг харуулж байгаа билээ.

Синантроптой адилтвар хүний эрүүний ясыг 1907 онд Германы Гейдельбург хэмээх газрын орчмоос олдсоныг **"Гейдельберг"** хүн хэмээн нэрийдсэн юм. Уг эрүүний яснаас үзэхэд гейдельберг хүний шүдний зохион байгуулалт нь орчин үеийн хүнийхнтэй үндсэндээ адил байсан байна¹⁶.

Ийнхүү хүний өвөг болох питекантроп, синантроп, гейдельберг, рамапитек зэрэг хүний амьдарч байсан орчин нь дулаан уур амьсгалтай байсан бөгөөд Африкийн ихэнх нутаг, хэсэг, Европ, Азийн өмнөх хэсгээс бусад газруудад төдийлөн тархаагүй байжээ.

Дундат плейстоцены эцсээр дээр дурьдсан хүн ба орчин үеийн хүний хоорондох завсарын үед амьдарч байсан хүний үлдцийг 1856 онд Германы Дюссельдорф хотын ойролцоох Неандертальин хөндийгөөс олжээ. Түүнийг анх олдсон газрын нэрээр **"Неандерталь"** хүн гэж нэршсэн байна. Энэ төрлийн насанд хүрсэн хүний ба хүүхдийн ясны үлдэгдэл Европ Африк, Азийн зэрэг дэлхийн ихэнх газраа олджээ. Неандерталь хүн нь дунд зэргийн нуруутай, шөрмөслөг, чийрэг биетэй, тархины багтаамж нь 1300-1600 см³ орчим байсан. Гэхдээ дух нь намхан, хөмсөгний яс нь шовгор гарын хуруунууд нь болхи зэрэг нь орчин үеийн хүнээс ялгагдах гол шинж нь байв¹⁷.

Харин элдэв төрлийн чулуун зэвсгээс гадны ясаар янз бүрийн хөдөлмөрийн багаж хийж, галыг зохиомол аргаар гаргаж чаддаг байсан нь төрөл бүрийн олдвороор нотлогдож байгаа юм. Неандерталь хүний амьдарч байсан орчин нь Мустьегийн үе бөгөөд эхэн үед цаг агаар урин дулаан байсан бол сүүл үед нь мөстлөг болсонтой холбогдон цаг агаар хүйтэрч ирсэн орчинд арслан, заан, буга зэрэг томоохон амьтдыг агнан амьдарч байжээ. Тэд гол төлөв агуй хонгилд амьдарч байсан боловч, задгай газар арслан заан зэрэг томоохон амьтдын ясаар овоохой барьж арьс ширээр нь хучлаг хийж байсан хэд хэдэн оромж сууц олдсон юм. Жишээлбэл Палестины Мугарт эс Схул орчмоос "ясан агуйн" үлдэцийг 1931-1932 онд археологичид олжээ¹⁸. Түүнчлэн Неандерталь хүний сууцнаас ясан зүү нилээд олдсоноос үзэхэд тэдгээр хүмүүс нь чулуун хянгараар арьс шир элдэж зөөлрүүлэн хувцас хунар хийж өмсдөг байсан нь илэрхий байгаа юм. Урьдын бүдүүлэг хүмүүсийг бодвол оюун ухаан, хөдөлмөрлөх ур чадвар, ихээхэн дээшилсэн неандерталь хүмүүс нь шинэ газар нутгийг эзэмшин суух боломжтой болсон нь сүүлийн үеийн археологийн судалгаанаас тодорхой болж байгаа билээ.

1868 онд Францын Лез-Эй-Жи Везер голын эрэгт буй **"Кро-маньон"** агуйгаас өндөр нь 180 см орчим, тархины багтаамж нь 1590 см³ бүхий орчин үеийн хүний олдворыг олдсон бөгөөд **"Кро-маньон"** гэж нэрлэжээ¹⁹. Түрүү ба дундат плестоцены туршид хувьсан өөрчлөгдөж ирсэн хүний төрх байдал нь цаашид хөгжиж **"кро-маньон"** нь орчин үеийн төрхийн хүн үүссэн эх суурийг тавьсан гэж судлаачид үзвэг.

¹⁶ Ю.И.Семенов. Как возникло человечество. М.1966. с.29

¹⁷ Всемирная история (каменный век), В томах, Том 1.Том1.М.

¹⁸ М.Ф. Неструх. Происхождение человека. М.1970г. с.288

¹⁹ М.Ф. Неструх, Происхождение человека. 1970 г. с. 358

“Кро-мань-он хүний гавлын яс нь томорч, дух нь өндөржиж ирсэн нь хөмсөгний ясны товгорыг арилгаж, хэл ярианы хөгжил болон үг ярианы аппарат өвчлөгдсөнтэй холбогдон эрүүний яс гарсан”²⁰ зэрэг түүний бие бялдарт чанарын томоохон өөрчлөлт гарсан байна.

Кро-маньон хүний олдвор нь Ази, Европ, Африк, Австрал зэрэг тив бүрээс олддог бөгөөд чухамхүү анх хаана үүссэн талаар эрдэмтэд, судлаачдын дотор олон саналууд байдаг. Орчин үеийн төрх бүхий хүний үүссэн газар нутгийн талаар эрдэмтэд түүхэн тодорхой үеүүдэд янз бүрийн үзэл баримтлал гарч байсан бөгөөд тэдгээрийг ерөнхийд нь хураангуйлан хоёр хуваан авч үзэх болсон юм.

Нэгдүгээрт: Моноцентризм буюу анх нэг газар нутагт үүсч аажмаар өсөж үржин дэлхийн бусад газар нутагт тархан суурьшсан гэсэн нэг төвт үзэл.

Хоёрдугаарт: Полицентризм буюу хүн анх хэд хэдэн газар нутагт үүсч аажмаар бусад газар нутагт тархсан гэх холимог төвийн үзэл онол байдаг. Эдгээрийн дотроос орчин шинжлэх ухаанд холимог төвийн (полицентризм) онолыг ихэнх судлаачид баримтлах болжээ.

Ялангуяа хүн анх үүссэн төв нь Төв Ази, Монгол газар нутаг гэдгийг олон судлаачид түүхэн баримтуудаар нотлох оролдлогуудыг хийж ирсэн байна. Хэдийгээр мичин хүний яс, хөдөлмөрийн багаж зэвсгийн үлдэц их төлөв, Африк, төв, зүүн өмнөт азиас олдсон боловч XX зууны эхэн үеэс хүн анх үүссэн өлгий нутгийн нэгэнд Төв Ази, Монголын говь нутаг мөн болохыг Америкийн нэрт эрдэмтэн Г.Ф.Осборн, В.Д.Мэтью нар зоригтой дэвшүүлсэн нь энэ талын судалгаа-шинжилгээгээр нотлогдож байгаа юм. Тэд нар төв Азийн амьтны аймгийн үүсэл гаралыг нарийвчлан судлаад эл нутаг нь маш эртний үеийн хүн дүрст бичний уугуул унаган нутагт онцлон тэмдэглэжээ. Энэхүү саналыг олон эрдэмтэд судлаачид дэмжсэн төдийгүй ялангуяа Д.Баррель Төв азийн газарзүйн тогтоц, хувьсал өөрчлөлтийг олдвор баримтанд үндэслэн **хүн дүрст мичний өвгийг Төв азид үүссэн болохыг тогтоожээ**²¹. Ер нь ихэнх тивүүдийн хүний өвөг Төв Азиас палиоцентын үед шилжин очсон болохыг тодруулж мичин хүний яс олдсон одоогийн мэдэгдэж байгаа газар нутгийг Төв Азиас нүүсэн мичин хүний хоёрдогч нутаг гэж тодорхойлсон байдаг. **Тиймээс ч олон орны үе үеийн байгал түүхийн судлаачдын судалгааг нэгтгэн дүгнэн авч үзвэл Төв Ази, монголын говь тал нутаг нь манай дэлхийн аймаг, хүн төрөлхтөний өлгий нутгийн нэг гэж үзэх бодит үндэслэлтэй юм.** Энэ нь байгаль, цаг уурын нөхцөлтэй холбон үзэж, хатуу ширүүн эрс тэрс уур амьсгалтай энэ нутагт эртний хүмүүсийн оюун ухаан, бие бялдар хувьсан хөгжих нөхцөл болж, амьдралын төлөө тэмцлийн явцад байгалийн хатуу ширүүн шалгарлаар хатуужин орчин цагийн хүн дүрсээ олсон юм гэсэн дүгнэлтийг хийсэн юм.

Америкийн нэрт эрдэмтэн Н.Х.Нельсон 1925 онд бусад нөхдийн хамт Монголын их говьд шинжилгээ, судалгаагаар ажиллаж, Өмнөговь аймгийн Баянзаг хэмээх газраас шинэ чулуун зэвсгийн асар их олдворыг судлан шинжлэх ухаанд нээлт хийж тэр нь “Говийн хийц” хэмээн шинжлэх ухаанд алдаршсан билээ²².

Эрдэмтэн Н.Х.Нельсон, Аляск орчимд эрдэм шинжилгээний судалгаа явуулж, тэндээс олдсон эд өглөгийн олдворууд нь Монгол нутгаас илрүүлсэн дурсгалуудтай адилхан болохыг тодорхойлж эндэхийн уугуул хүн ам нь Төв Ази Монголоос нүүдэллэн ирсэн хүмүүс гэж үзсэн юм. Түүний энэхүү дүгнэлт гаргалгаа нь дараа дараагийн судалгаагаар нотлогдсоор байгаа юм. Тухайлбал Оросын эрдэмтэн А.П.Окладников Аляск, Алеутын арлууд дээр хийсэн судалгааны үр дүнд

²⁰ Всемирная история, Каменный век. В 24 томах, Том 1. М.1996 г с 57

²¹ Монгол Улсын түүх, УБ., 2006, тал 41

²² Ж.Болдбаатар, Монголчууд дэлхий дахины түүхнээ, УБ., 2007. тал 7-8

Америк тивийн хамгийн эртний үед холбогдох дурсгал нь монголын Ярхи, Баянзагийн олдворуудтай ижилдүү төдийгүй хийсэн арга барил нь адилхан байсан гэсэн дүгнэлтийг хийжээ. Тиймээс **"Америкийн индианчуудын эртний өвөг дээдэс Азиас гаралтай, тэндээс нүүдэллэн очсон полиондианчууд мөн"**²³ гэжээ.

Түүнчлэн монгол нутаг, хүн анх бий болсон өлгий нутгуудын нэг төдийгүй Америк тивийг анх нээсэн буюу өвөг монголчууд тус тивийн Алеутад хөл тавьж нээсэн таамаглалыг монголын зарим судлаачид дэвшүүлж түүнийгээ археологийн олдворууд, газар усны нэр, хэл соёл, зан заншлаар батлах оролдлогуудыг хийж байгааг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байгаа билээ²⁴.

Abstract: The paper discusses about the issue of human origin. Based on the archaeological findings, historical sources and other evidences, the author talks about timing and evolutionary stages, changes in body structure and the role of labor in primate-human transition process.

Ном зүй

1. К.Маркс, Ф.Энгельс, Түүвэр зохиол. III боть, УБ. 1971
2. Всемирная история, Том 1. М.1955 г.
3. Всемирная история, "Каменный век" В томах, Том 1. М. 1996 г.
4. Всемирная. История учебник для вузов, М.1997 г.
5. А.Ж.Тойнби. Постигение истории, М. 1991 г.
6. История древнего мира, Том 1. М. 1979 г.
7. А.И.Першиц. Б.П.Алексеев. История первобытного общества. М. 1999 г.
8. 8.М.Ф.Нестурх, Происхождение человека. М. 1985
9. А.И.Яковец. Соёл иргэншлийн түүх. УБ., 1999
10. Дэлхий дахины түүх. I боть, УБ., 2002
11. Монгол улсын түүх, тэргүүн боть, УБ., 2003
12. Монгол улсын түүх. УБ., 2006
13. Вопросы истории. № 3, 5, 1980, № 2,6 1987
14. Түүх III. Эрдэм шинжилгээний бичиг, МУИС, №288, УБ., 2004
15. Ж.Болдбаатар, Монголчууд дэлхий дахины түүхнээ, УБ., 2007

²³ А.П.Окладников. Центральнo Азиатский очаг. Первобытного искусства, Вестник Ан СССР, 1967г.№1

²⁴ Өнөөдөр сонин, 2008, III сар №